



ПРЕМИУМ НЭКСУС ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2025 оны 09 сарын 17 өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

Баталгаа гаргах,
сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай

Монгол Улсын Иргэний хуулийн 234 дүгээр зүйл, Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 76 дугаар зүйлийн 76.1.17 дох заалт, 91 дүгээр зүйлийн 91.2 дох заалт, 92 дугаар зүйл, Премиум Нэксус ХК ("Компани")-ийн Дүрмийн 9 дугаар зүйлийн 9.4.18-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

- Компанийн нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд болох Финко Капитал ББСБ ХХК-ийн Биржийн бус зах зээлд хаалттай хүрээнд доорх нөхцөл бүхий "Финко Капитал-2" өрийн хэрэгсэл ("Бонд" гэх) гаргаж байгаатай холбогдуулан Бондын эргэн төлөлтийн үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар Финко Капитал ББСБ ХХК-ийн нэрийн өмнөөс 4,200,000,000 (дөрвөн тэрбум хоёр зуун сая) төгрөгийн Бондын төлбөр (үндсэн болон хүүгийн төлбөр)-ийн үүргийн гүйцэтгэлд баталгаа гаргахыг Компанид зөвшөөрсүгэй.

Үнэт цаасны нэр	"Финко Капитал-2" бонд
Нийт татан төвлөрүүлэх дүн	3,000,000,000 төгрөг
Үнэт цаасны хүү	Жилийн 20.0%
Үнэт цаасны санал болгох хугацаа	24 сар
Хүү төлөх хуваарь	Улирал тутам
Үндсэн төлбөр төлөх хуваарь	Хугацааны эцэст

- Энэхүү тогтоолд заасны дагуу Бондын үүргийн гүйцэтгэл хангуулахтай холбоотой баталгааны гэрээг үүрэг гүйцэтгэгч Финко Капитал ББСБ ХХК болон Тэнгэр Капитал ҮЦК ХХК-тай байгуулах, шаардлагатай бусад баримт бичигт баталгаа гаргагч Компанийг төлөөлөн гарын үсэг зурах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал (А.Ганхуяг)-д олгосугай.

(Гарын үсгийн хуудас дагалдана)

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА (ХАРААТ БУС):



ГАРИ БИОНДО

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:

А.ГАНХУЯГ

А.ГАНБОЛД

Г.БАТ-ЭРДЭНЭ

Ч.МӨНХЧИМЭГ

Г.ЧИНЗОРИГ

Б.БАТ-ЭРДЭНЭ

Ө.ЭРДЭНЭЧИМЭГ

В.ГАНЗОРИГ